



IX/2021


Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 13



Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 300.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 9 дүгээр сард ат 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 11.3 мянган төгрөгөөр, хязаалан гунын үнэ 1.2 сая төгрөг болж, өмнөх сараас 600 төгрөгөөр тус тус буурсан байна. Соёолон үрээний үнэ 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 9.2 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 145.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Харин эр хонины үнэ 209.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.5 мянган төгрөгөөр, буурсан байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), 2021 оны 9 дүгээр сард, мянган төгрөгөөр




Эр хонь 2021 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 60.0 мянган төгрөгөөр, Дорнод аймагт хамгийн бага буюу 157.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 9 дүгээр сард сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 9 дүгээр сард цагаан ноолуурын 1кг-ын дундаж үнэ Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 120.0 мянган төгрөг, Баянхонгор аймагт хамгийн бага буюу 55.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. ЦАГААН НОолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2021 оны 9 дүгээр сард, төгрөгөөр




Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2021 оны 9 дүгээр сард 7.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.5 мянган төгрөгөөр, ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 98.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.1 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 9 дүгээр сард боодолтой өвсний (20кг) үнэ Архангай аймагт хамгийн их буюу 13.5 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 4.7 мянган төгрөг байна.

ЗУРАГ 5. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 9 дүгээр сард, төгрөг



25 кг хивэгний үнэ 2021 оны 9 дүгээр сард Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 26.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 3500 төгрөгөөр нэмэгдэж, Говь-Алтай аймагт хамгийн бага буюу 15.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 2300 төгрөгөөр буурсан байна.

Тооцох аргачлал

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын
Үнийн статистикийн хэлтсийн
гэрээт ажилтан Б.Оргил
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212